



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот


ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн  
сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааны  
удирдамж батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал Н.Ганзориг)-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

367040036



ШУТИС-ийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 70 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ШУТИС-ИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа “ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”, “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам” болон энэхүү удирдамжийг удирдлага болгон мөрдөнө.

Бүрэлдэхүүн сургуулийн салбар, тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах комисс, Захиргаа, хүний нөөцийн газар хамтран нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

### Нэг. Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

- 1.1. ШУТИС-ийн бүх мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын нээлттэй сонгон шалгаруулалтыг хамт олноос нэр дэвшүүлэн өрсөлдүүлэх зарчмаар явуулна.
  - 1.1.1. 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хойш мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгч нь томилогдсон албан тушаал дээр сонгон шалгаруулалт явуулахгүй.
  - 1.1.2. ШУТИС-д үндсэн албан тушаалд ажилладаг ажилтан нь салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан бол нэр дэвшин өрсөлдөх боломжтой.
  - 1.1.3. Гадны байгууллагад ажилладаг хүнийг ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.
- 1.2. Сонгон шалгаруулалтад оролцогч нь салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолт болон “ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 7.2.3-т заагдсан нөхцөлийг хангасан байх шаардлагатай.
  - 1.2.1. Мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд мэргэжлийн чиглэлээр тухайн салбартаа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлж чадах, шинийг санаачилж багаар ажиллах чадвартай, доктор (Ph.D), дэд профессороос доошгүй зэрэг, цолтой эрдэмтдээс сонгон шалгаруулна.
  - 1.2.2. Хэрэв заагдсан эрдмийн зэрэг, цолны нөхцөлийг хангах нэр дэвшигч тухайн салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд өрсөлдөхөөр бүртгүүлээгүй тохиолдолд хамт олны дундаас доктор (Ph.D) зэрэгтэй нэр дэвшигч, нэрээ дэвшүүлж болно. (Биеийн тамир, спортын тэнхимийн хувьд эрдмийн зэрэг, цолгүй боловч тухайн тэнхимд харьяалагддаг спортын зэрэг цолтой багш нараас нэр дэвшихийг зөвшөөрнө)

ШУТИС-ийн захирлын 2022 оны 02 дүгээр сарын 12-ны өдрийн 404 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## Хоёр. Сонгон шалгаруулалт зохион байгуулах үе шат, үнэлгээ

2.1. ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгч сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь дараах үе шаттайгаар зохион байгуулагдана.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх, нэрсийг Захиргаа, хүний нөөцийн газарт ирүүлэх	2022.01.12- 2022.01.13-ны өдрүүдэд	Бүрэлдэхүүн сургуулийн захирал
2	Одоо ажиллаж буй салбар, тэнхимийн эрхлэгч нар сонгон шалгаруулалтад оролцох бол ажилласан хугацааны тайланг урьдчилан хамт олонд танилцуулах	2022.01.12- 2022.01.13-ны өдрүүдэд	Бүрэлдэхүүн сургуулийн захирал
3	Тухайн бүрэлдэхүүн сургуулийн салбар, тэнхимийн эрхлэгчид нэр дэвшигч нар хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилт, төлөвлөгөөг тухайн хамт олноор хэлэлцүүлэн үнэлүүлэх	2022.01.12- 2022.01.17-ны өдрүүдэд	Бүрэлдэхүүн сургуулийн захирал
4	Бүрэлдэхүүн сургуулийн удирдлага нэр дэвшигчийг үнэлэх	2022.01.17- 2022.01.18-ны өдрүүдэд	Бүрэлдэхүүн сургуулийн захирал
5	Тухайн салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд өрсөлдөн, хамгийн өндөр үнэлгээ авсан 2 нэр дэвшигчийн үнэлгээ, холбогдох материалыг Мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэгт ирүүлнэ.	2022.01.19-нд	Бүрэлдэхүүн сургуулийн захирал
6	ШУТИС-ийн Захирал, захиргааны холбогдох нэгжүүдийн үнэлгээ	2022.01.19- 2022.01.20-ны өдрүүдэд	Захиргаа, хүний нөөцийн газар
7	Сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн, мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд томилсон ШУТИС-ийн Захирлын тушаал гаргах	2022.01.21-нд	Захиргаа, хүний нөөцийн газар



ШУТИС-ийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 104 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

2.2. Мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын нээлттэй сонгон шалгаруулалтад нэр дэвшигчдийг үнэлэх үнэлгээ:

2.2.1 Тухайн салбар, тэнхимийн хамт олны үнэлгээ - 45 хүртэл оноо

- ✓ Нэр дэвшигч бүр тухайн салбар, тэнхимийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамт олонд танилцуулан үнэлүүлнэ.
- ✓ Хамт олны санал өгөх хуралдааныг 85 хувиас дээш ирцтэйгээр зохион байгуулна. Нэр дэвшигч бүрээр нууцаар санал хурааж, онооны хувийг гаргана.
- ✓ Одоо ажиллаж буй салбар, тэнхимийн эрхлэгч нар сонгон шалгаруулалтад оролцох бол ажилласан хугацааны тайланг хамт олноороо заавал хэлэлцүүлнэ.

2.2.2 Бүрэлдэхүүн сургуулийн удирдлагын үнэлгээ - 25 хүртэл оноо

- ✓ Мэргэжлийн салбар, тэнхимийн эрхлэгч нарыг оролцуулахгүйгээр, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн бусад гишүүдийн өгсөн нийт саналын хувиар тооцон оноог гаргана.

2.2.3 ШУТИС-ийн Захирал, захиргааны холбогдох нэгжүүдийн үнэлгээ - 30 хүртэл оноо

- ✓ Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр ШУТИС-ийг хөгжүүлэх чиглэлд өмнө оруулсан хувь нэмэр, оролцоог захиргааны холбогдох нэгжүүдийн саналыг үндэслэн үнэлнэ.

•



ШУТИС-ийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 709 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**Тухайн мэргэжлийн салбар, тэнхимийн хамт олны үнэлгээ  
(45 хүртэл оноо)**

д/д	Бүрэлдэхүүн сургууль	Салбар, тэнхимийн нэр	Нэр дэвшигчийн нэр	Эрдмийн		Их дээд сургуульд ажилласан жил	Үзүүлэлт, оноо		Нийлбэр оноо /45 хүртэл оноо/
				цол	зэрэг		нэр дэвшигчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилт, төлөвлөгөө /35 хүртэл оноо/	Нэр дэвшигчийн манлайлах үр чадвар, үр чадвар, чадамжид өгөх үнэлгээ /10 хүртэл оноо/	
1									
2									
3									

Жич:

- Саналыг нууцаар хураана.
- Хамгийн олон санал авсан нэр дэвшигч 45 оноо авсан байхаар оноог хүн бүрт хувиран бодно.

**Бүрэлдэхүүн сургуулийн удирдлагын үнэлгээ  
(25 хүртэл оноо)**

д/д	Бүрэлдэхүүн сургууль	Салбар, тэнхимийн нэр	Нэр дэвшигчийн нэр	Эрдмийн		Их дээд сургуульд ажилласан жил	Бүрэлдэхүүн сургуулийн удирдлагын багийн үнэлгээ /25 хүртэл оноо/
				цол	зэрэг		
1							
2							
3							

Жич:

- Саналыг нууцаар хураана.
- Хамгийн олон санал авсан нэр дэвшигч 25 оноо авсан байхаар оноог хүн бүрт хувиран бодно.





ШУТИС-ийн захирлын 2022 оны 02 дүгээр сарын 12-ны өдрийн 40 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ШУТИС-ИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Ганзориг	Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга:	Ж.Арслан	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга
Гишүүд:	Д.Гэрэлт-Од Т.Энхцацрал Б.Нарантуяа А.Энхбат Г.Баттүвшин К.Хавалболот Ц.Энхбаатар Ц.Батбаатар Д.Цолмонбаатар Н.Чулуунбанди Ж.Туяацэцэг В.Өлзийбаяр Б.Бат-Эрдэнэ Д.Болдбаатар	СБЗГ-ын дарга ЭШИГ-ын дарга БАС-ийн захирал БуХС-ийн захирал БАТС-ийн захирал ГУУС-ийн захирал ГХС-ийн захирал ДаТС-ийн захирал МехТС-ийн захирал МХТС-ийн захирал ҮТС-ийн захирал ХШУС-ийн захирал ЭХС-ийн захирал ШУТИС-КТК-ийн захирал